

МОНГОЛ ХЭЛНИЙ ОЙРОЛЦОО НЭГЖИЙГ
БОДИТ БОЛООД ХИЙСВЭР УТГЫН ТАЛААС АВЧ ҮЗЭХ НЬ

Б.Мөнгөнцэцэг

Түлхүүр үг: бодит буюу юмжуулах харьцаа, хийсвэр буюу дохиожуулах харьцаа, ойролцоо дагавар, ойролцоо өгүүлбэр

Сүүлийн үед ойролцоо нэгжийг хэлний түвшдийн хүрээнд олон талаас нь судлах болжээ. Хэлний нэгжүүд давхарлан шаталсан тогтолцоог бүтээхдээ ойролцоо ба эсрэг, төсөөт ба зүйлчилсэн утгатай байх ба эдгээр хэлний нэгжүүдээс монгол хэлний ойролцоо үгийг нэлээд судалсан боловч бүтээврийн болоод өгүүлбэр, цогцолборын түвшинд судалсан эрдэмтдийн санал харилцан адилгүй, нарийвчлан судлах шаардлага байсаар байгаа юм. М.Базаррагчаа, Б.Мөнгөнцэцэг нар “Монгол хэлний ойролцоо үг үүсэх эх сурвалжийг нэг талаас, бодит юм үзэгдэлтэй шууд холбоо бүхий юмжуулах харьцаа (денотативное отношение)-нд, нөгөө талаас, юм үзэгдэлтэй шууд холбоогүй, харин юмын шинж чанар, хөдөлгөөнтэй холбоотой дохиожуулах харьцаа (сигнификативное отношение)-нд үндэслэдэг ажээ... Адил буюу ойролцоо утгатай үгийг синоним гэж үздэг тул энэхүү ойролцоо үг нь нэг бол, янз бүрийн юмыг нэг ухагдахуунаар нэрлэдэг (хийсвэр буюу дохиожуулах харьцааны үүднээс), эсвэл нэг юмыг янз бүрээр нэрлэдэг (бодит буюу юмжуулах харьцааны үүднээс) гэсэн хэрэг болно. Ийм ялгаатай байгаа эсэх нь ойролцоо үгийн хэв шинжийн ангиллын анхны баримжаа болно” гээд, ойролцоо үгийг 1) туйлын (1.бүрх = шял, дэлгүүр = хоршоо, тоншуул = цондуул, 2.хөхөө = хөгөлзөргөнө), 2) оновчтой (1.гомдол ≠ гоморхол, хүмүүнлэг ≠ хүмүүнч, шавар ≠ шавхай, хагалалт ≠ хагалбар ≠ хагарал ≠ хагаралт ≠ хагадас; хагал- ≠ хагач-; 2.хооловч = хүзүүвч, 3.даар- ≠ бээр- ≠ осго- ≠ хөлд-), 3) оновчтой бус (1.өвгөд ≠ өтгөс ≠ дээдэс ≠ урьдас; 2.нөхөр ≠ сүүдэр, хувь ≠ тавилан), 4) хуурмаг (1.унт- ≠ нойрс- ≠ дугжир- ≠ хажуул-, 2.ярь- ≠ өгүүл- ≠ хүүрнэ- ≠ хөөр- ≠ хуучил- ≠ чалч- ≠ бур-) (2011: 26) гэж ангилжээ.

Энэ санааны дагуу бага нэгж нь их нэгжээ агуулдаг, их нэгж нь бага нэгжээ багтаадаг харьцаанд нь тулгуурлан, тодруулбал, монгол хэлний ойролцоо бүтээврийг судлахдаа дээд түвшний нэгж болох ойролцоо үгтэй нь; ойролцоо өгүүлбэрийг судлахдаа бага түвшний нэгж болох ойролцоо үгтэй нь харьцуулж, улмаар тус бүрийн онцлогийг бодит болоод хийсвэр утгын талаас тодруулан гаргахыг зорилоо. Үүний тулд дараах зорилтыг дэвшүүлсэн болно.

- I. 1. Монгол хэлний ойролцоо дагаврын салаа утгыг тодорхойлохдоо тухайн язгуур үндсийн утгаас хэрхэн шалтгаацаж байгаагаар нь ялган авч үзэх;
2. Монгол хэлний ойролцоо дагаврын салаа утгыг бодит болоод хийсвэр утгын талаас харьцуулан, илрэх хэлбэр, утга, онцлогийг гаргах;
- II. 1. Монгол хэлний ойролцоо өгүүлбэрийг бодит буюу юмжуулах харьцаанд нь үндэслэн, бодит үйл явдал, түүнээс төрөгдөх санаа болоод бүтэх аргын хувьд ялгаж, илрэх хэлбэр, онцлог, зүй тогтлыг гаргах;

2. Монгол хэлний ойролцоо өгүүлбэрийг хийсвэр буюу дохиожуулах харьцаанд нь үндэслэн, бодит үйл явдал, түүнээс төрөгдөх санаа болоод бүтэх аргын хувьд ялган, илрэх хэлбэр, онцлог, зүй тогтлыг гаргах;

В.Гумбольдт “Үг бол тухайн юмыг төлөөлсөн зүйл биш... Харин юмын тухай манай өөрсдийн санаа үзлийн илрэл мөн... Нэгэн ижил зүйлийг олон янзаар илрүүлдгийн гол сурвалж чухам үүнд л байгаа хэрэг. Жишээ нь: Хэрвээ санскрит хэлэнд зааныг хоёр удаа ундлагч гэх буюу хоёр шүдэт, эсвэл гараар зэвсэглэсэн гэх зэргээр нэрлэх нь хэдийгээр нэг юмыг хэлж байгаа боловч эдгээр нэр тус бүрдээ тусгай ухагдахууныг агуулж байна (1964: 102) гэсэн бол, А.А.Реформатский “Синонимын утга (ухагдахуун) нь ойролцоо буюу адил биш, харин нэрлэж байгаа юм нь адил, ойролцоо байдаг (1955: 62) гэжээ. Энэ нь утга бодит утга, хийсвэр утга гэсэн нэг юмыг хоёр талаас үзсэнтэй холбогдоно. Ийнхүү ойролцоо үгийн үүслийг В.Гумбольдт хийсвэр утгаас нь, А.А.Реформатский бодитой утгаас тайлбарласан нь үгийн утгын ба үгийн хэлбэрийн үүднээс үзсэнд оршино. Тэгвэл хэлний ойролцоо байх чанар нь нэг талаас юмтай (денотат), нөгөө талаас утгатай (сигнификат) харьцсан холбоонд үндэслэдэг ажээ. Ю.С.Степанов “Ойролцоо утга нь ихээхэн нарийн зүйл бөгөөд бүтцийн хувьд юм болоод ухагдахуунд хамаарах гэсэн хоёр хандлага байдгийг бид нэгэнт дурдсан болно. Иймээс ойролцоо үгсийг нэг бол ижил юм (синонимия по денотату), эсвэл ижил ухагдахуунтай холбоотой юм (синонимия по сигнификату) гэж үзэж болох юм” (1975: 27-30) гэжээ.

Хэлний нэгж бүр ойролцоо утгатай байх ба “Монгол хэлний үгийн язгуур ба дагаварт ойролцоо утга байдгаас үгийн сангийн салангид үгс - нэрлэлтүүд ойролцоо утгатай болдог байна. Бас хэл зүйн утгатай морфемууд ойролцоо утгатай байж болдог учраас бүтэц өгүүлбэрийн дотор харьцаанд орсон буюу эсвэл харьцаанд ороход бэлтгэгдсэн хэлзүйжсэн үг буюу хэлбэржсэн үгэнд ойролцоо утга гардаг байна. Нэгэнт хэлбэржсэн үгс (өгүүлбэр зүйн үг) ойролцоо утгатай байж болдгоос үүдэж, нийлмэл үг, хоршоо үг, хэвшмэл хэлц, тэрчлэн чөлөөт бус холбоо үгс ч өөр хоорондоо ойролцоо утгатай байж болох зүй тогтол гарна. Эдгээр нь цаашлаад өгүүлбэрүүдийн хооронд улмаар цогцолбор ба “эх” -үүдийн хооронд ойролцоо утга үүсэх нөхцөлийг бүрдүүлдэг байна” (Пүрэв Очир, 2000: 166). Ийнхүү ойролцоо нэгж нь үг төдийгүй бусад нэгжид байх ба тэдгээрийг юмжуулах (бодит) ба дохиожуулах (хийсвэр) гэсэн хоёр талаас үзэж болно. Энэхүү юмжуулах буюу юмын утга нь хэлний бус үйл ба хэрэг явдлын тухай үнэн мэдээлэл агуулах ба энэ нь дотроо ертөнцийн юм үйл ба хэрэг явдлаас өгүүлэгч этгээд хэл яриандаа хэрэглэхийг онцолсон утга (актуальный денотат (референт), ертөнцийн олон юм, үйл ба хэрэг явдлыг өгүүлэгч этгээд хэл яриандаа хэрэглэх боломжтой утга (виртуальный денотат (денотат) гэсэн хоёр янз. Тэгвэл дохиожуулах буюу ухагдахууны утга нь ертөнцийн юмсын тухай мэдээлэл хүний ухамсарт хэрхэн илэрч буйг илтгэнэ. Дохиожуулах утга нь юмсын тухай гэнэн ойлголт (ухагдахуун)-д таарч байх ба ухагдахууны хоорондох харьцааг гаргахад оршино. И.М.Кобозева орос хэлний “Мама спит” (Ээж унтана) гэхэд “мама” нь “хүн, эмэгтэй, төрүүлэгч” гэсэн утганцартай бол “спать” нь “амьтны бодит шинж, амрах нэг хэлбэр, бүхнийг умартах бололцоотой болох” гэсэн утганцраас бүтнэ (2000: 59-60) гэж тайлбарлаад, “Юмжуулах харьцааны онцолсон утга нь янз бүрийн дохиожуулах утга бүхий зүйлсээр илрэх үед юмжуулах ба дохиожуулах утгын ялгаа тодорхой илэрдэг” гэжээ.

1. Монгол хэлний ойролцоо дагаврын утгыг бодит болоод хийсвэр утгын талаас ялган авч үзэх нь:

М.Базаррагчаа, Ж.Баянсан нар “ойролцоо бүтээвэр (утгалбар, утгат хэсэг): -дал -ц (-dal, -sa...): яв-дал ~ яв-ц, суу-дал ~ суу-ц...; -дал -аас (dal, -ya-su-): оё- дол ~ оё-оос, зур-дал ~ зур-аас; -ээр -ээс (yari, -yasu): үд- ээр ~ үд-ээс, сүлбэ-ээр ~ сүлбэ-ээс...” (1997:58) гэж үзсэн бол Н.Б.Дугаров буриад хэлнээ ойролцоо утгатай дагавруудыг нэг язгуурт залгаж, ойролцоо үг бүтээх нь элбэг ба эдгээр нь утгаараа нэн ойр, ихэвчлэн найруулгын өнгө аясыг ялгадаг (1978: 25) гээд, ойролцоо дагаврыг жагсаасны дээр ойролцоо утга бүхий төсөөт үг бүтэхийг *заһалта* - *заһабари* - *заһабарилга*, *ажаглах* - *ажаглалга* - *ажаглалта* зэрэг жишээгээр тайлбарлажээ.

Т.Н.Павлов “Ойролцоо утгатай бүтээвэр нь өөр хоорондоо бүрэн тохирохын зэрэгцээ заримдаа эргэлзээтэй байдаг ч тэдгээрийн утгаараа ялгарах нь янз бүр байдаг ойролцоо утгын нэгэн хэв маяг болдог. Ойролцоо утгат дагавар нь тухайн эхийн дотор харилцан сольж болох, утгаараа адил өөр дагаврууд байдаг” (2007: 89) гэж үзсэн байна. “Дагавар бүтээврийн утга нь язгуурын утгыг бодвол илүү хийсвэр шинжтэй байдаг. Ийм учраас дагаврын утгыг тодорхойлохдоо тухайн дагаврыг залгаж байгаа үгийн үгсийн сан- утга зүйн шинжийг бас анхаарах нь зүйтэй” (1983: 114) гэж үзсэнийг бид арга зүйн чухал баримжаа болгон авч үзсэн болно.

Монгол хэлний ойролцоо дагаврын утгыг нэг талаас, бодит юм үзэгдэлтэй шууд холбоо бүхий юмжуулах харьцаа, нөгөө талаас, юм үзэгдэлтэй шууд холбоогүй, харин юмын шинж чанар, хөдөлгөөнтэй холбоотой дохиожуулах харьцааны үүднээс ялган үзэж болно. Бид монгол хэлнээ түгээмэл хэрэглэгддэг бүтээлч дагаврын нэг болох үйл үгээс нэр үг үүсгэдэг “-дал, -ц” дагаврын салаа утгаар жишээлэн авч үзлээ. Үүнд:

I. юмжуулах буюу бодит харьцаа

юмыг заасан

-дал

1. а. зүйдэл } зардал	}	хэрэглүүр
б. буудал } суудал	}	үйлийн болох орон
в. оргодол	}	үйл гүйцэтгэгч
г. боодол } өргөдөл	}	үйлээр бүтсэн юм

II. дохиожуулах буюу хийсвэр харьцаа

юмыг заагаагүй

-ц

1. а. гишгэц } дэлгэц	}	хэрэглүүр
б. сууц } гарц	}	үйлийн болох орон
в. зарц } хоноц	}	үйл гүйцэтгэгч
г. нөөц } тарьц	}	үйлээр бүтсэн юм

у
т
г
а

2. алхдал }
 гишгэдэл }
 ороодол } янз байдал

2. а. ирц }
 хийц } янз байдал

б. шингэц }
 даац } хэмжээ

Дагавар тус бүр үг бүтээх чадамжаараа харилцан адилгүй бөгөөд бидний сонгон авсан “-дал” дагавраар 28, “-ц” дагавраар 103 үг бүтэж байна. Эдгээр дагавраар илрэх утга нь чухам ямар үндсэнд залгаснаас хамаарч өөр өөр байгааг харьцуулан авч үзье.

	1.а. хэрэглүүр		1.б. үйлийн болох орон		1.в. үйл гүйцэтгэгч		1.г. үйлээр бүтсэн юм		2.а. янз байдал		2.б. хэмжээ	Нийт	
	-дал	-ц	-дал	-ц	-дал	-ц	-дал	-ц	-дал	-ц	-ц	-дал	-ц
1. өөрийн эрхээр хөдлөх утга бүхий				4				1	6	15	8	6	28
2. өөрийн эрхгүй хөдлөх утга бүхий		5	1				1		2	6	7	4	18
3. орших утга бүхий			1	2					2	4		3	6
4. бүтээн хөдлөх утга бүхий	3		2	1	1		4	5	5	17	9	15	32
5. бүтээлгүй хөдлөх утга бүхий		1				3		1		3	10		18
6. тусган хөдлөх утга бүхий										1			1
Бүгд	3	6	4	7	1	3	5	7	15	46	34	28	103

Бодит буюу юмжуулах харьцааны үүднээс, үйл үгээс нэр үг үүсгэдэг “-дал, -ц” дагаврыг ихэвчлэн өөрийн эрхгүй хөдлөх, бүтээн хөдлөх утга бүхий үйл үндсэнд залгахад юмыг зааж, улмаар үйлийн болох орон, хэрэглүүр, үйл гүйцэтгэгч, үйлээр бүтсэн юмыг заасан утга цөөн боловч илэрч байгаа бөгөөд үүнээс үйлээр бүтсэн юмыг заасан утга нь олонтоо байна.

Хийсвэр буюу дохиожуулах харьцааны үүднээс, үйл үгээс нэр үг үүсгэдэг “-дал, -ц” дагаврыг ихэвчлэн өөрийн эрхээр болон эрхгүй хөдлөх, бүтээн хөдлөх утга бүхий үйл үндсэнд залгахад юмыг заалгүй, улмаар үйлийн янз байдал заасан утга илтгэж байна. Түүнчлэн үйл үгээс нэр үг үүсгэдэг “-дал, -ц” дагаврыг ойролцоо утгат дагавар болох эсэхийг тодорхой шалгуураар авч үзлээ. Ш.Лувсанвандан салаа утга ба ойролцоо утгын талаар өгүүлэхдээ “Үгийн салбар олон утгатай байдаг учир үүнд холбогдон утга харилцан ойр байх явдал дан ганц үгийн гол утгаар илрэлээ олох бус мөн үгийн салбар утгад холбогдож болно” (1962: 45) гэсэн бөгөөд энэ тухайд Ю.Д.Апресян “Эцсийн эцэст, салаа утга, ойролцоо утга хоёр нь хам цагийн үүднээс ч нарийн холбоотой юм. Олон утгат үг уг ёсоороо хэд хэдэн ойролцоо үгийн үүр эгнээнд ордог. Үүнийг тэмдгээр илэрхийлбэл тохиромжтой юм. Хэрэв “А” гэдэг үг нь а, б, в, г гэсэн салаа утгатай бол А, Б, В, Г гэсэн ойролцоо үгийн эгнээнд “а” орж болно. “б” нь А, Л, М, Н-д, “в” нь А, О, П, Р-д тус тус орж болно. Тэгвэл Б, В, Л, М, О, П нь мөн л олон утгатай болно” (1957: 85) гэж үзжээ. Иймд орчин цагийн монгол хэлний үг бүтээх дагаврын салаа утгын нийлэх нь олон, ялгарах нь цөөн бол тэдгээрийн утга ойртох тул ойролцоо утгат дагавар болно.

2. Монгол хэлний ойролцоо өгүүлбэрийн утгыг бодит болоод хийсвэр утгын талаас ялган авч үзэх нь:

М.Базаррагчаа монгол хэлний ойролцоо өгүүлбэрийг ангилах тухайд “...ижил санаа бүхий өгүүлбэрүүд нь тухайн бодит юм, үзэгдлийн ижил шинжтэй, ойролцоо санаа бүхий өгүүлбэрүүд нь хэд хэдэн юмс үзэгдлийн тухай ойролцоо санаатай тус тус холбогдоно. Үүний эхнийх нь хэлний ойролцоо өгүүлбэр болох ба сүүлчийнх нь хэлэхийн ойролцоо өгүүлбэр буюу тойруулал болно” (1987: 335) гэж үзсэн бол Д.Бадамдорж “Нийлмэл өгүүлбэрийн бүрэлдэхүүнд багтсан өгүүлбэрүүд өөр хоорондоо ойролцоо утга санаа илэрхийлж болно. Жишээлбэл: 1. Чанарын ойролцоо утга санаа: а. Аавын сургаал алт б. Ээжийн сургаал эрдэнэ;

2. Үйлийн ойролцоо утга санаа: *а. Аавын уургийг барьж сур б. Адуу мал чинь өснө...* гэхчлэн зан чанарын, үйл явдлын, цагийн, шалтгааны, шинжийн, зүдгүүрийн ойролцоо утга санаа” гэж 8 ангилан үзсэн байна (2001: 94).

Монгол хэлний ойролцоо өгүүлбэр үүсэх эх сурвалжийг “зэрэгцүүлэн буй уг үйл явдал нь нэг, эсвэл үйл явдал нь өөр хэдий ч санаа нь төстөйд тус тус тулгуурлана” гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, монгол хэлний ойролцоо өгүүлбэр нь нэг талаас, бодит юм үзэгдэл буюу үйл явдалтай шууд холбоо бүхий юмжуулах харьцаанд, нөгөө талаас, юм үзэгдэлтэй шууд холбоогүй, харин үйл явдлаас үүдэлтэй холбоо бүхий дохиожуулах харьцаанд үндэслэдэг ажээ.

Монгол хэлний ойролцоо өгүүлбэр нь ойролцоо утгат гишүүдээс гадна илтгэж буй санаагаараа ижилсэн бүтэж байгааг бодит болоод хийсвэр утгын талаас ялган авч үзье. Үүнд:

1. а. Бодит утгын талаас, монгол хэлний ойролцоо өгүүлбэр нь ижил санааг илтгэхдээ хоёроос дээш гишүүд нь зүйлийн үгээр бодит үйл явдлыг давтахын зэрэгцээ ойролцоо үгээр ялгарсан байна. Жишээ нь:

Арван гурван наснаас тавин зургаан насыг хүртэл Шарын гол ба Улаанбаатар хоёрын хооронд Дагвын өвсийг зөөж, Балдангийн түлээг тээсээр өдий хүрсэн тул зам дахь уул давааг ч андахгүй, энхэл донхлыг ч эндэхгүй, нүхнээс гарч хошихирох тарвагыг ч бараг таних бөгөөд нисэн өнгөрч одох шувууг ч төлөв мэднэ (Д.Нацагдорж) гэхэд “бараг-төлөв”, “таних-мэдэх” гэсэн хийсвэр утга бүхий оновчтой ойролцоо үг¹, “тарвага-шувуу” зэрэг зүйлийн үгсээр бодит үйл явдлыг давтсан байна. Тодруулбал, өгүүлэхүүнийг ойролцоо гишүүнээр ижилсүүлж, шууд тусагдахууныг зүйлчлэн ондоошуулсан байна.

Тэнгэрийн хаяанаас чинагш газар байдгийг мэдэж, таван далай таван тивийг танин шинэ ертөнц дээр хамт явах замыг нээв (Д.Нацагдорж) гэхэд “таних-мэдэх” гэсэн хийсвэр утга бүхий оновчтой ойролцоо үг, “газар-тив” зэрэг зүйлийн үгсээр бодит үйл явдлыг давтсан байна.

Үг гэвэл тогтоогоод ав

Үсэг гэвэл цээжлээд ав гэсэн өгүүлбэрийг бүтээж буй гишүүн нь “цээжлэх-тогтоох” бодит утга бүхий хуурмаг ойролцоо үг², “үг-үсэг” хэмээх хүний бүтээсэн зүйлийн нэрээс бүтэж, “сурсан бүхэн эрдэм” гэсэн санааг агуулжээ.

б. Бодит утгын талаас, ижил санааг илтгэхийн тулд тухайн ойролцоо өгүүлбэрээр бодит үйл явдлыг давтан, эс адилтган бүтээсэн байна.

Нэгэн залуу хүүхэн жолоог дугтран зүтгүүлсээр гарч ирэхүй нь зэрлэг бугын адил өнгөтэй ба цог заль гэрэлтэн, жавхлантай нь түмэн баатар эрсийн боловч зүрхийг чичрүүлэн догдлуулж, төв эрдэмт оюунтны боловч хүслийг холбилзуулан татна (Д.Нацагдорж) гэхэд хүний зүйлийн нэр (баатар эр-эрдэмт оюунтан)-ээр бодит үйл явдлыг давтахын зэрэгцээ эс адилтган нэг санааг илтгэж буй тул бодит ойролцоо өгүүлбэр болно.

Хэдийгээр ухаан сэргэлэн хэмээвч, зүүн хошууны зах дор хүрсэн үгүй, баруун мөрний тэртээ гарсан үгүй, зөвхөн гурав дөрвөн өртөө эргэн тойрон газрын дотор оришин суусан тул, юуг үзэж мэдэж, юуг олж сонсох ажээ (Д.Нацагдорж) гэхэд зүйлийн үг (хошуу-мөрөн)-ээр бодит үйл явдлыг давтахын зэрэгцээ эс адилтган нэг санааг илтгэсэн байна.

Уулын бартааг явж мэднэ

Усны гүнийг гаталж мэднэ гэхэд “ямар нэг хэргийг бүтээхэд саад бэрхшээл тохиолддог” хэмээх санааг илтгэхдээ сонгож авсан гараг ертөнцийн зүйл (уул-ус) нь бодитой байхын зэрэгцээ эс адилтган өгүүлсэн тул бодит ойролцоо өгүүлбэр болно.

¹ Хоёр ойролцоо үгийн нийлэх утганцар нь олон, ялгарах утганцар нь цөөн бол тэдгээрийн утга ойртох тул хийсвэр утга бүхий оновчтой ойролцоо үг болно.

² Тухайн эхэд төрөл (род) зүйл (вид)-ийн харьцааг илтгэж, утгын ялгаа нь бүдгэрч саармагшсан бол бодит утга бүхий хуурмаг ойролцоо үг болно.

Зэвсэгт эрийг айлгаж

Зэв тоногийг булаадаг

Илдэт эрийг няцааж

Илүү дутууг булаадаг

гэхэд “зорьж буй үйлээс нь эсвэл сэтгэлийн их хүчийг нь алдагдуулан шантраах” хэмээх санааг илтгэхдээ “зэвсэг-ерөнхий, илд-тодорхой”, “зэв тоног-тодорхой, илүү дутуу-ерөнхий” гэсэн ерөнхий-тодорхой утгат бодитой юм (хүний бүтээсэн зүйл)-ыг сонгон авсны зэрэгцээ бодит ертөнцийн үйл явдалтай тохирч буй тул бодит ойролцоо өгүүлбэр болно.

II. а. Хийсвэр утгын талаас, тухайн ойролцоо өгүүлбэрийн хоёроос дээш гишүүд нь ойролцоо үгээр ялгарч, улмаар ойролцоо санаа илтгэнэ. Жишээ нь:

Хоёр хүн довцог дээр гараад холыг ширтэн, алсыг ажна (Ч.Чимид) гэсэн өгүүлбэрт буй “алс-хол”, “ширтэх-ажих” нь хийсвэр утга бүхий оновчтой ойролцоо үг болно. Тодруулбал, “ширтэх-ажих” нь харааны эрхтнээр мэдрэх үйлийг заах боловч “ширтэх” нь нарийвчлан харах, “ажих” нь анхаарч харах гэсэн утгын нарийн ялгамжтай байна.

...өдрийн өнгөрлийг түмэн удаа эргэцүүлэн санаж, мянга дахин мөрөөдөн хүсэхийн дээр... (М.Ядамсүрэн) гэхэд “түмэн удаа-мянган дахин” нь бодит тоон утгаараа адилгүй ч тухайн хам сэдэвтээ “олонтоо” гэсэн утга илтгэх бодит утга бүхий хуурмаг ойролцоо үг (зүйл-зүйл), “санах-хүсэх” нь хийсвэр утга бүхий оновчтой ойролцоо үг болно.

Өргөвч өөдлөхгүй

Тэтгэвч дэгжихгүй гэсэн өгүүлбэр нь “өргөх-тэтгэх”, “өөдлөх-дэгжих” гэсэн хийсвэр утга бүхий оновчтой ойролцоо үг бүхий гишүүдээр ижилсэн холбогдож, “а. сэхэл засал авахгүй, унхиагүй, б.хүний тус мэдэхгүй” гэсэн санаа илтгэжээ.

Санасаар суугаад саарал

Бодсоор суугаад буурал гэсэн өгүүлбэр нь “санах-бодох” хийсвэр утга бүхий оновчтой ойролцоо үг, “буурал-саарал” хийсвэр утга бүхий оновчтой бус ойролцоо үг³-ээс бүтэж, “ажил үйлс нь бүтэмжгүй, юм хийдэггүй” гэсэн санааг илтгэжээ. Тодруулбал, “буурал болох-саарал болох” нь “хөгшрөх” гэсэн утгыг үсний өнгөөр нь төлөөлүүлсэн тул хийсвэр утга бүхий оновчтой бус ойролцоо үг болно.

б. Хийсвэр утгын талаас, ойролцоо санааг илтгэхийн тулд бодит санааг хийсвэр санаатай ил ба далд адилтган, улмаар ойролцоо өгүүлбэр бүтээнэ.

“Ингээд богдын хүрээний гуйлгачны тоо нэгээр өсөж, баатар зоригт гэгдэж байсан хуяг таяг тулсан гуйлгачин болов” гэхэд эхний өгүүлбэр нь гуйлгачин болсон тухай ерөнхий санааг заасан бол дараагийн өгүүлбэр нь мөн үйл явдлын тухай тодорхой санааг өгүүлжээ. Үүнээс үзвэл, *цөм Цэрмаагийн хийсэн ба болгосон идээ мөн.* Гэрийн эзэд шинэ хувцсыг өмсөөд, битүүлнэ хэмээн баяртай жавхлантайгаар хөдөлцгөөнө. *Цэрмаа гал тогоотой хуримлана (Д.Нацагдорж)* гэхэд Цэрмаагийн хийж болгосон идээг гал тогоогоор нь солин нэрлэхийн зэрэгцээ түүнийгээ “...хуримлах” гэж амьдчилан адилтгаснаар энэ хоёр өгүүлбэр ойролцоо санаатай өгүүлбэр болжээ.

Морь эцэвч эмээлээ даана

Мод эцэвч мөчрөө даана гэхэд хүний тухай өгүүлсэн “а. өтөлснөөс үхсэн биш, б.чоно өтлөвч ишгэндээ, цорж өтлөвч балиндаа” гэсэн хийсвэр санаа нь хоосноор илэрсэн ба уг хийсвэр санааг “мод, морь” хоёрыг адилтгасан хоёр өөр бодит үйл явдлаар далд адилтган, хийсвэр ойролцоо өгүүлбэр бүтээсэн байна.

³ Нэг үгийн гол ба салаа утга нь нөгөө үгийн гол ба салаа утгатай ойролцоо байж, дүрслэх ур маягаар бүтсэн бол хийсвэр утга бүхий оновчтой бус ойролцоо үг болно.

Хүн ёс дагана

Нохой яс дагана гэхэд хоёр өөр санаатай боловч эхний өгүүлбэрийн хийсвэр санааг удаах өгүүлбэрийн бодит санаатай ил адилтгаж, “ёс ёмбогор, төр төмбөгөр” гэсэн ойролцоо санаа бүхий өгүүлбэр бүтээсэн байна. Тодруулбал, дагалт өгүүлбэр нь хүний тухай өгүүлсэн өгүүлбэрийн санааг чимэхийн дээр адилтгуулагч болсон байна.

Дүгнэлт

Бид монгол хэлний ойролцоо дагавар, ойролцоо өгүүлбэрийг авч үзэхдээ хэлний бага нэгж нь их нэгжээ агуулдаг, их нэгж нь бага нэгжээ багтаадаг харьцаанд нь тулгуурлан, тус бүрийг бодит болоод хийсвэр утгын талаас харьцуулан авч үзсэн болно. Үүнд:

а. Монгол хэлний ойролцоо дагаврын илтгэж буй салаа утгын ихэнх нь таарвал тэдгээрийн утга нь ойртож, салаа утгын ихэнх нь ялгарвал ойролцоо утга нь холдоно гэж үзэж байна. Тодруулбал, үйл үгээс нэр үг үүсгэдэг “-дал, -ц” дагаврын салаа утгыг тодорхойлон харьцуулахад зөвхөн хэмжээ заасан утгаараа ялгаран, ихэнх нь таарч, улмаар тэдгээрийн утга нь ойртох тул ойролцоо утгат дагавар болно гэж үзэж байна.

Монгол хэлний ойролцоо дагаврыг бодит болоод хийсвэр утгын талаас авч үзэхдээ, үйлээс нэр үг үүсгэх “-дал, -ц” дагавраар жишээлэн, тус бүрийн салаа утгыг харьцуулсан бөгөөд хийсвэр утгын талаас, бүтээн хөдлөх, өөрийн эрхээр хөдлөх утга бүхий үйл үндсэнд залгахад үйлийн янз байдал заасан утга илтгэх нь олонтоо байна.

б. Монгол хэлний ойролцоо өгүүлбэрийг бодит болоод хийсвэр утгын талаас авч үзсэн нь агуулгын талд хамаарах бөгөөд эдгээр нь уг үйл явдал нэг юм уу, эсвэл үйл явдлын тухай санаа төстөйд тулгуурлана гэж үзэж болно.

Бодит ойролцоо өгүүлбэр нь зүйлийн үгээр бодит үйл явдлыг давтан, нэг санаа илтгэж байна. Үүгээрээ хийсвэр ойролцоо өгүүлбэрээс ялгагдана. Түүнчлэн бодит ба хийсвэр ойролцоо өгүүлбэрийг бүтээхэд ойролцоо гишүүн чухал үүрэгтэй болох нь хэлний баримтаас харагдаж байна.

Бодит ойролцоо өгүүлбэр нь нэг санааг илтгэхийн тулд бодит үйл явдлыг давтан, эс адилтган бүтсэн байдаг бол хийсвэр ойролцоо өгүүлбэр нь бодит санааг хийсвэр санаатай ил ба далд адилтган, улмаар ойролцоо санааг илтгэж байна.

Abstract

We defined the suffix “dal, ts”, which forms noun from verb, to the verb roots of active or active in a movement it expresses the mood and size of the action, mostly. When studying the extra meaning of suffix “dal, ts”, forms noun from verb, the meaning of size is distinguished in it's meaning, most of them in a common so that the closer their meaning they can be considered as synonym suffix.

Synonymous sentences had considered according to the fact and opinion so it will be the content side and they will be considered those events based on the one or events which has similar idea. To express same meaning, fact synonymous sentence repeat the real events and forms not identical but significant synonymous sentence similize fact meaning with significant meaning using as metaphor and paraphrase even express synonymous meaning.

Ном зүй

- Апресян Ю.Д.** 1957. *Проблема синонима*. Вопросы языкознания. №6. Москва.
- Бадамдорж Д.** 2001. Монгол хэлний утга судлал. Гутгаар дэвтэр. Улаанбаатар.
- Базаррагчаа М.** 1987. Монгол хэлний өгүүлбэр. Улаанбаатар.
- Базаррагчаа М., Мөнгөнцэцэг Б.** 2011. *Монгол хэлний ойролцоо үгийг мэдэгдэхүүн, мэдэхүүн ба хэлэгдэхүүн, хэлэхүүний талаас үзэх нь*. Монгол судлал. XXXII (328): 14- 27. Улаанбаатар.
- Базаррагчаа М., Баянсан Ж.** 1997. *Монгол хэл, уран зохиолын лавлах*. Улаанбаатар.
- Баянсан Ж.** 1983. *Монгол хэлний нэгэн дагавар бүтээврийн утга зүйн асуудал*. МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. №3 (83). Улаанбаатар.
- Гумбольдт В.** 1964. О различии строения человеческих языков и его влиянии на духовное развитие человеческого рода, В кн.: *В.А.Звегинцев. История языкознания XIX-XX веков в очерках и извлечениях*. ч.1. Москва.
- Дугаров Н.Б.** 1978. Лексические синонимы в современном бурятском литературном языке. Москва.
- Кобозева И.М.** 2000. *Лингвистическая семантика*. Москва.
- Лувсанвандан Ш.** 1962. *Үгсийн сангийн зүй*. Бээжин.
- Павлов Т.Н.** 2007. *Разновременная словообразовательная синонимия в древнерусских житиях*. Системное и асистемное в языке и речи. (Материалы международной научной конференций. Иркутск, 10-13 сентября 2000 года). Иркутск.
- Пүрэв-Очир Б.** 2000. *Орчин цагийн монгол хэлний өгүүлбэр зүй*, Дэд дэвтэр. Улаанбаатар.
- Реформатский А.А.** 1955. *Введение в языкознание*. Москва.
- Степанов Ю.С.** 1975. *Основы общего языкознания*. Москва.